

**“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ТУШААЛААР ӨГӨГДСӨН  
ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2018.09.14

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын 62 тушаалын 113 заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Захирлын тушаалын хэрэгжилтийн байдалд 2018 оны III улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн 67, 70%-ийн хэрэгжилттэй 17, 30%-ийн хэрэгжилттэй 6, хэрэгжээгүй 10, хугацаа болоогүй 6, хүчингүй болсон 1, үнэлэх боломжгүй 6 заалттай биелэлт **81,3** хувьтай байна.

Захирлын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх нэгжийн тус бүрээр гаргавал дараах байдалтай байна:

№	Нэгж, ажилтны нэр	Заалт	Үүнээс /хувиар/						Биелэлт /хувь/
			100	70	30	Хэрэгжээгүй	Хугацаа болоо- гүй	Хүчин- гүй болсон	
1	ХЗХБХ	24	14	5	2	1	2	-	82,27
2	ТМССХ	17	7	5	3	1	1	-	71,25
3	ЗСХ	80	52	13	4	8	3	-	80,47
4	Бусад	12	1	7	-	1	2	1	65,56

Төвийн захирлын 2017 оны 6, 2018 оны 56, нийт 62 тушаал хяналтад байгаагаас 12 нь ажлын хэсэг, байнгын ажиллагаатай болон орон тооны бус комисс, зөвлөл томилсон, 10 нь төлөвлөгөө хуваарь баталсан болон цагийн асуудалтай холбоотой, 5 нь журам, хөтөлбөр баталсан, 31 нь нэг удаагийн үүрэг даалгавар хэрэгжүүлэхтэй холбоотой, 4 нь бусад төрлийн тушаал байна.

Хяналтад байгаа 62 тушаалын 113 үүрэг даалгавраас хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон, хүчингүй болсон, нэг удаагийн шинжтэй 43 тушаалын 61 заалтыг хяналтаас хаслаа.

Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн индекс батлуулах, Төвийн 5 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсэг томилсон, Төвийн лого шинэчлэх, уралдаан зохион байгуулах тухай, Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан, шилэн кабелийн өмчлөлийг төрийн мэдэлд шилжүүлэх асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан Захирлын 5 тушаалын 6 заалт нь хугацаа болон ач холбогдлоо алдсан, хэрэгжүүлэх боломжгүй болсон учир хүчингүй болсонд тооцож хяналтаас хасуулах шаардлагатай байна.

Захирлын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах асуудалд нэгж, ажилтнууд анхаарч ажилласаны үр дүнгээр тушаалын хэрэгжилт 2018 оны эхний хагас жилийн дүнгээс 8,3 хувиар өссөн байна.

**Санал, зөвлөмж:**

1. Нэгж, ажилтнууд хэрэгжүүлэх хугацаа хэтэрсэн болон удаашралтай хэрэгжиж байгаа үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлэх;

2. Тушаалын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, шаардлагатай бол хэрэгжилтийн явц, байдлыг Захирлын шуурхай зөвлөгөөнд танилцуулж байх;

3. Хэрэгжүүлэх боломжгүй болсон, цаг хугацааны хувьд ач холбогдолоо алдсан, давхардсан үүрэг даалгавар өгсөн зарим тушаалын заалтыг нэгтгэх, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох;

4. Тодорхой асуудлаар санал боловсруулах, дүгнэлт гаргах, судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг олон байгуулахгүй байх, үүнээс үүдэн нэгж, ажилтны дунд ажил цалгардах, хугацаа алдах асуудал гарч байгаад дүгнэлт хийж тухайн нэгжийн эрхлэх асуудал, чиг үүргийн хүрээнд хариуцсан нэгж, ажилтнаар гүйцэтгүүлэх;

5. Ажилтнуудыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахдаа давхардуулахгүй байх, оролцоог жигд хангах;

6. Тушаалд тухайн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой заах;

7. Албан хэрэг хөтлөлтийн журамд заасны дагуу үүрэг болгосон, даалгасан, ажил, үүргийн чиглэлийн дагуу холбогдох ажилтан захирлын тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг сар бүрийн 30-ны дотор тайлагнаж хэвшүүлэх;

8. Захирлын тушаалаар үүрэг даалгавар авсан нэгж, ажилтан үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж ажиллах, үр дүнг тогтмол мэдээлэх, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнг бүрэн хариуцах;

9. Захиргааны асуудал хариуцсан нэгж нийт ажилтанд хамааралтай тушаалыг ажилтнуудад заавал танилцуулах, тушаалын эх болон хуулбар хувь олгосон бүртгэлийг хөтлөх ажлыг тогтмолжуулах;

10. Тушаалаар үүрэг даалгавар авсан нэгж, ажилтан биелэлтийг өөрөө хариуцаж гаргах, хэрэгжилтийн байдлыг нэгтгэх ажилтанд тогтоосон хугацаанд хүргүүлэх.

ТАНИЛЦСАН:

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ

Т.АРИУНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДАХА

Э.ОСОРЖАМАА